ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022/70/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........ 2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
3. Аудитын тайлан ........ 10
 3.1 Ерөнхий зүйл ........ 10
 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 10
 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
 3.4 Материаллаг байдал ........ 11
 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 11
 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11
 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 13
 3.8 Аудитын гол асуудал ........ 13
 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 14
4. Аудитын илрүүлэлт ........ 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn
2022.02.14 № 01
танай ______________-ны № ______________-т

НАСАН ТУРШИЙН
БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Н.ДОЛЖИНСҮРЭН ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2022-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 18,184,758.50 | 14,174,767.20 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 50,000.00 | 500.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 50,000.00 | 500.00 |
| 3121 | Төгрөг | 50,000.00 | 500.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 50,000.00 | 500.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 18,134,758.50 | 14,174,267.20 |
| 351 | Түүхий эд материал | 17,169,348.50 | 13,419,377.20 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 16,417,348.50 | 13,041,977.20 |
| 35130 | Эм боох материал | 752,000.00 | 377,400.00 |
| 354 | Хангамжийн материал | 965,410.00 | 754,890.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 630,410.00 | 704,790.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 157,500.00 | 32,600.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 177,500.00 | 17,500.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,460,950.22 | 18,767,030.82 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,460,950.22 | 18,767,030.82 |
| 392 | Биет хөрөнгө | 2,160,950.18 | 18,567,030.74 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 49,805,755.18 | 61,655,325.18 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (48,140,230.57) | (48,350,640.11) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,013,975.00 | 31,651,975.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (25,518,549.43) | (26,389,629.33) |
| 393 | Биет бус хөрөнгө | 300,000.04 | 200,000.08 |
| 39301 | Програм хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (99,999.96) | (199,999.92) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 20,645,708.72 | 32,941,798.02 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 187,917.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 187,917.00 |
| 413 | Өглөг | - | 187,917.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 187,917.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 20,645,708.72 | 32,753,881.02 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 20,645,708.72 | 32,753,881.02 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 317,638,399.00 | 317,638,399.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 317,638,399.00 | 317,638,399.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (1,009,260,179.57) | (997,152,007.27) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,009,260,179.57) | (1,009,260,179.57) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 12,108,172.30 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 712,267,489.29 | 712,267,489.29 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 20,645,708.72 | 32,941,798.02 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **295,664,810.00** | **314,107,295.45** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **19,067,470.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 19,067,470.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 19,067,470.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 19,067,470.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **295,664,810.00** | **295,039,825.45** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 262,848,800.00 | 262,253,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 262,848,800.00 | 262,253,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 125,825.45 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 125,825.45 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,678,400.00 | 32,660,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,678,400.00 | 32,660,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **299,202,883.36** | **301,999,123.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **299,202,883.36** | **301,999,123.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 296,644,972.36 | 300,048,256.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228,884,484.00 | 231,148,078.00 |
| 210101 | Үндсэн цалин | 185,212,732.00 | 146,501,189.00 |
| 210102 | Нэмэгдэл | 30,955,819.00 | 67,229,666.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,110,800.00 | 1,233,052.00 |
| 210104 | Урамшуулал | 11,605,133.00 | 16,184,171.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,199,600.00 | 29,783,598.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,687,483.00 | 20,807,784.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,803,858.00 | 2,193,783.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,026,530.00 | 1,845,428.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 425,520.00 | 448,546.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,256,209.00 | 4,488,057.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,122,000.00 | 31,122,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 31,122,000.00 | 31,122,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,491,355.00 | 4,296,141.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 330,650.00 | 86,070.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 401,605.00 | 177,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,347,000.00 | 408,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 412,100.00 | 156,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 3,467,971.30 |
| **2105** | **Нормативт зардал** | 195,000.00 | 38,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 127,000.00 | 17,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 68,000.00 | 21,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 301,800.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 301,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,752,533.36 | 3,358,639.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 274,300.00 | 670,850.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,322,233.36 | 2,687,789.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,557,911.00 | 1,950,866.45 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 850,000.00 | 49,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 850,000.00 | 49,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,707,911.00 | 1,901,366.45 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,707,911.00 | 1,901,366.45 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(3,538,073.36)** | **12,108,172.30** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(3,538,073.36)** | **12,108,172.30** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 317,638,399.00 | 712,267,489.29 | (1,005,584,496.21) | 24,321,392.08 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **317,638,399.00** | **712,267,489.29** | **(1,005,584,496.21)** | 24,321,392.08 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (3,675,683.36) | (3,675,683.36) |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **317,638,399.00** | **712,267,489.29** | **(1,009,260,179.57)** | 20,645,708.72 |
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **317,638,399.00** | **712,267,489.29** | **(1,009,260,179.57)** | 20,645,708.72 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **317,638,399.00** | **712,267,489.29** | **(1,009,260,179.57)** | 20,645,708.72 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 12,108,172.30 | 12,108,172.30 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **317,638,399.00** | **712,267,489.29** | **(997,152,007.27)** | 32,753,881.02 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **295,664,810.00** | **295,075,839.45** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **295,664,810.00** | **295,075,839.45** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 262,848,800.00 | 262,253,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 262,848,800.00 | 262,253,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 125,825.45 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 125,825.45 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,678,400.00 | 32,660,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,678,400.00 | 32,660,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 137,610.00 | 36,014.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 137,610.00 | 36,014.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **295,977,200.00** | **295,125,339.45** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **295,977,200.00** | **295,125,339.45** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **293,419,289.00** | **293,138,459.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228,884,484.00 | 230,701,955.00 |
| 210101 | Үндсэн цалин | 185,212,732.00 | 146,055,066.00 |
| 210102 | Нэмэгдэл | 30,955,819.00 | 67,229,666.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,110,800.00 | 1,233,052.00 |
| 210104 | Урамшуулал | 11,605,133.00 | 16,184,171.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,199,600.00 | 30,041,804.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,687,483.00 | 21,065,990.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,803,858.00 | 2,193,783.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,026,530.00 | 1,845,428.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 425,520.00 | 448,546.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,256,209.00 | 4,488,057.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,122,000.00 | 31,122,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 31,122,000.00 | 31,122,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,442,905.00 | 237,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 401,605.00 | 177,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,985,500.00 | 40,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 412,100.00 | 20,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 204,400.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 204,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 430,300.00 | 831,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 274,300.00 | 831,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,557,911.00** | **1,986,880.45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 850,000.00 | 85,514.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 36,014.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 850,000.00 | 49,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,707,911.00 | 1,901,366.45 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,707,911.00 | 1,901,366.45 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(312,390.00)** | **(49,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (312,390.00) | (49,500.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 50,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 50,000.00 | 500.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 294,914,000.00 | 293,078,459.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 294,914,000.00 | 293,078,459.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 294,914,000.00 | 293,078,459.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 230,714,700.00 | 230,701,955.00 |
| 210101 | Үндсэн цалин | 133,379,900.00 | 146,055,066.00 |
| 210102 | Нэмэгдэл | 79,081,500.00 | 67,229,666.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,817,000.00 | 1,233,052.00 |
| 210104 | Урамшуулал | 16,436,300.00 | 16,184,171.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,530,100.00 | 30,041,804.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,301,600.00 | 21,065,990.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,307,100.00 | 2,193,783.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,845,700.00 | 1,845,428.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 461,400.00 | 448,546.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,614,300.00 | 4,488,057.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,455,900.00 | 31,122,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,338,100.00 | - |
| 210302 | Түлш, халаалт | 16,005,600.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,112,200.00 | - |
| 210304 | Байрны түрээс | - | 31,122,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 177,000.00 | 177,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 177,000.00 | 177,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 204,400.00 | 204,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 204,400.00 | 204,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 831,900.00 | 831,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 831,900.00 | 831,300.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 294,914,000.00 | 293,078,459.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 262,253,700.00 | 261,752,059.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 262,253,700.00 | 261,752,059.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 32,660,300.00 | 31,326,400.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 32,660,300.00 | 31,326,400.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **50,000.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **500.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 18.00 | 18.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 105.00 | 86.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 105.00 | 86.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 105.00 | 86.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **18.00** | **18.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 12.00 | 12.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6.00 | 6.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **60,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **60,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 60,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 60,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 40,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 125,825.45 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 125,825.45 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 125,825.45 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Насан туршийн боловсролын төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Насан туршийн боловсрол төв нь орон нутгийн насан туршийн болон албан бус боловсролын байгууллагыг нэгдсэн удирдлага, бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг эрхэлдэг.

“Бүх насны иргэдийн суралцах нээлттэй орчин нөхцөлийг сайжруулан, хүний нөөцийг чадавхжуулж насан туршийн боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ” зорилготой, дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

- Насан туршийн боловсролын агуулгын хүрээнд сургалтын хөтөлбөрийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэх
- Мэдээлэл технологийн ололтыг сургалтад ашиглахад дэмжлэг үзүүлж, багш, ажилтныг ажлын байранд тасралтгүй хөгжих боломжийг нэмэгдүүлэх
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, суралцагчийн бие даан сурах үйлийг дэмжих
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн төвийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчлах
- "Хүүхэд хамгааллын бодлого"-ын хэрэгжилтийг хангах, сургалтын орчинд аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Насан туршийн боловсролын төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 4,412.9 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 294,194.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,412.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,089.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Насан туршийн боловсролын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,296.1 мянган төгрөгөөр буюу 59.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 50.0 | 0.5 | (49.5) |
| Бараа материал | 18,134.8 | 14,174.3 | (3,960.5) |
| Үндсэн хөрөнгө | 2,460.9 | 18,767.0 | 16,306.1 |
| **Нийт хөрөнгө** | **20,645.7** | **32,941.8** | **12,296.1** |
| Өр төлбөр | | 187.9 | 187.9 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 20,645.7 | 32,753.9 | 12,108.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **20,645.7** | **32,941.8** | **12,296.1** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.5 мянган төгрөг болж 49.5 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтаас шалтгаалжээ.

Бараа материалын данс 14,174.3 мянган төгрөг болж 3,960.5 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18,767.0 мянган төгрөг болж 16,306.1 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-аас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ажил мэргэжлийн чиг баримжаа, мэдээллийн төвийн ажлын хэрэгцээнд 18,993.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга нийлүүлснийг орлогоор бүртгэж, аймгийн Засаг даргын 2021 оны А/165 дугаар тушаалаар 1,506.3 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 187.9 мянган төгрөг болж нэмэгдсэн нь цалингийн нэгдсэн систем болон санхүүгийн тайлангийн программын тооцооллоос шалтгаалан ажилтнуудаас илүү суутгаж тооцсон татвар, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 32,753.9 мянган төгрөг болж 12,108.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Насан туршийн боловсролын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 18,580.1 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар, нийт зардал өмнөх оноос 6,873.8 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар тус тус өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Насан туршийн боловсролын төв 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 324,810.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 324,810.6 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 57,934.8 мянган төгрөгөөр бууруулан 266,875.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 1 удаа тодотгол хийж 28,038.2 мянган төгрөгөөр нэмж, 294,914.0 мянган төгрөгөөр баталжээ. Өмнөх оноос цалингийн зардлыг бууруулж баталсныг тодотгосон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх насан туршийн болон албан бус боловсрол хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 262,353.7 мянган төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 32,660.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 293,078.4 мянган төгрөгийг зарцуулж, 1,835.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 293,078.4 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 12.7 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 488.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,333.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Бараа материалын данс 14,174.3 мянган төгрөг болж 3,960.5 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18,767.0 мянган төгрөг болж 16,306.1 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-аас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ажил мэргэжлийн чиг баримжаа, мэдээллийн төвийн ажлын хэрэгцээнд 18,993.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга нийлүүлснийг орлогоор бүртгэж, аймгийн Засаг даргын 2021 оны А/165 дугаар тушаалаар 1,506.3 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 187.9 мянган төгрөг болж нэмэгдсэн нь цалингийн нэгдсэн систем болон санхүүгийн тайлангийн программын тооцооллоос шалтгаалан ажилтнуудаас илүү суутгаж тооцсон татвар, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 32,753.9 мянган төгрөг болж 12,108.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Насан туршийн боловсролын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 18,580.1 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар, нийт зардал өмнөх оноос 6,873.8 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар тус тус өссөн байна.

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Насан туршийн боловсролын төв 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 324,810.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 324,810.6 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 57,934.8 мянган төгрөгөөр бууруулан 266,875.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 1 удаа тодотгол хийж 28,038.2 мянган төгрөгөөр нэмж, 294,914.0 мянган төгрөгөөр баталжээ. Өмнөх оноос цалингийн зардлыг бууруулж баталсныг тодотгосон байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх насан туршийн болон албан бус боловсрол хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 262,353.7 мянган төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 32,660.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 293,078.4 мянган төгрөгийг зарцуулж, 1,835.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 293,078.4 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 12.7 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 488.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,333.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСУГ-аас 60.0 мянган төгрөгийн ариутгалын, 65.8 мянган төгрөгийн элсэлтийн ерөнхий шалгалтын бичиг хэргийн зардлын санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 60.0 мянган төгрөгийг ариутгал халдваргүйтгэлийн зарлага гаргаж, үлдэгдэл 65.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Насан туршийн боловсрол төв нь 2021 онд нийт 336,364.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 336,364.8 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин байрны түрээс 10-12 сард цахим төлбөрийн е-баримтгүй зөвхөн түрээсийн гэрээ, нэхэмжлэхтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5 дахь заалт, Сангийн сайдын 2017 онд баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,230.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | 1 | 1,230.0 | 1 | 1,230.0 | | | |
| Зөвлөмж | 1 | | 1 | | | | |
| Нийт дүн | 2 | 1,230.0 | 2 | 1,230.0 | | | |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,338.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 446.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 8,892.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Тооцоолсон цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд 446.1 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн ба төрийн албаны нэгдсэн цалингийн систем болон санхүүгийн программд тооцоолсон цалингийн зөрүүг тулгаж хянаагүйгээс албан хаагчдаас илүү суутгасныг өр төлбөрөөр бүртгээгүйг залруулав.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь

хяналт тавих", 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах.

**2. *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Байрны түрээсийн 10-12 сарын 8,892.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ е-баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5 дахь заалт, Сангийн сайдын 2017 онд баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Насан туршийн боловсролын төв | 4 | 9,338.1 | 2 | 446.1 | | | | | 2 | 8,892.0 |